

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
02 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2020 оны 2-р сарын 06-ны өдөр хуралдаж Тариат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн Хамба хутагтын дүрийг тодруулах хүсэлтийг танилцуулах тухай, Шагналын тухай, Өмчийн тухай, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хуваарилалтын тухай, Ой тэмдэглэх тухай /Булган ЕБС-70, Эрдэнэмандал ЕБС-90, Ихтамир ЕБС-70, Цахир сумын ЕБС-80, Эрдэнэбулган сумын 1-р цэцэрлэг 70 жилийн ой/, Архангай аймгийг Түрк улсын Бурса хотын Османгази дүүрэгтэй хамтран ажиллах чиглэлийг дэмжих тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажилд хяналт тавин ажиллаж, бүрдүүлэлтийн ажлыг хугацаанд нь дуусгах талаар сумдын эрх бүхий албан тушаалтанд зөвлөмж чиглэл өгч мэдүүлэг гаргах 517 албан тушаалтан мэдүүлгээ хугацаанд бүрэн гаргаж, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдүүлгийн хураангуй тайлан, бичмэл тайланг бичиж 2-р сарын 20-нд Авлигатай тэмцэх газарт цахимаар хүргүүллээ.

2-р сард улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Өгийнуур сумын Орхон багийн иргэн хэлмэгдэгч Сэдийн Гомбозовын төрсөн охин Дэнсмаад 40.000.000 /дөчин сая/ төгрөг, Эрдэнэбулган сумын 5-р багийн иргэн хэлмэгдэгч Цэрэндэндэвийн Далайн төрсөн хүү Ёндонжамцад 40.000.000 /дөчин сая/ төгрөгийг тус тус олгох шүүхийн шийдвэр гарсны дагуу нөхөх олговрын мөнгийг дансанд шилжүүлж, батламж гардуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт 2-р сарын 20-ны өдөр хугацаанд нь хүргүүллээ.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 278 дугаар захирамжийн дагуу сум, агентлаг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж журмын дагуу сайн ажилласан сум, байгууллага, сургууль, цэцэрлэгийг шагнаж урамшуулахаар шийдвэрлүүлсэн.

2-р сарын 07-ны өдөр Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг дарга агентлагийн дарга, сумын Засаг дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал цэцэрлэгийн эрхлэгч нартай 2019 оны үр дүнгийн гэрээ, хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Аймгийн ЗДТГ болон бусад төрийн байгууллагууд байгууллага, нэгж, төрийн албан хаагчийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 37, 38 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар

тушаалаар баталсан журам, загварын дагуу батлуулан хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдалд хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

“Шуурхай штаб”-ыг аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд төвлөрүүлэн, аймгийн Онцгой комиссын гишүүдийг 09:00-22:00 цагт ажиллуулж, аймгийн удирдлага болон холбогдох дээд шатны байгууллагуудыг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

Мөн сумдад Шуурхай штаб байгуулж хүч хэрэгслийг томилгоожуулан бэлтгэл бэлэн байдлыг хангаж, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Онцгой комисс 5 удаа хуралдаж коронавирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2 албан даалгавар, 4 захирамж гаргаж, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий аймгийн “Шуурхай штаб”-ыг Засаг даргын тамгын газарт ажиллуулж сум орон нутгийн мэдээллийг нэгтгэн улсын Онцгой комисс, хойд бүсийн төв, бусад холбогдох албан тушаалтнуудыг мэдээ мэдээллээр ханган үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.

Улсын Онцгой комиссын 2-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар 2-р сарын 23-ны өдрийн 08.00 цагаас 27-ны өдрийн 08.00 цаг хүртэл хугацаанд улс, хот хоорондын тээврийн хөдөлгөөнийг хязгаарласныг 3-р сарын 03-ны өдрийн 08.00 цаг хүртэл сунгах шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Архангай аймгийн Онцгой комиссын 5 дугаар хуралдааныг хуралдуулж Архангай аймаг, сумын төвөөс гарах, орох иргэд, автомашины хөдөлгөөнийг зогсоох хугацааг 2020 оны 3-р сарын 03-ны өдрийн 08.00 цаг хүртэл сунгахаар шийдвэрлэж постуудын тоог нэмж, хяналт шалгалтыг чангатгах чиглэл өглөө.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлтийн талаар

Тайлант сард улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100% биелүүлж байна.

2020 оны 01-р сарын нэмэгдсэн өртгийн албан татварын 221 тайлан цахимаар тайлангийн ирцийг 100.0 хувь, 2019 оны жилийн эцсийн аж ахуйн нэгжийн тайлангийн ирцийг 96 хувь, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын тайлангийн ирцийг 98 хувь, төлбөр хураамжийн тайлангийн ирцийг 100 хувь, хувь хүний орлогын албан татварын тайлангийн ирцийг 85 хувь хангуулж ажилласан.

Өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Орон нутгийн өмчит 5 төсөвт байгууллагад 35.3 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгосон байна.

Санхүүгийн хяналтын чиглэлээр

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 1, 2, 3, 4, 5, 14 дүгээр цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчийн нийт 19 төрлийн актаар 20.7 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож хариуцагчдаар төлүүлэх, 7.6 сая

ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг-5, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг байхгүй байна.

Нийт 1596 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 1527 иргэнд 45.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 252.3 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 17.4, нийт гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 1.9 хувьтай байна

Шүүхийн шинжилгээний албанаас 2-р сард криминалистикийн шинжилгээ 6, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 93, шүүх эмнэлгийн шинжилгээ 40, тусгай шинжилгээ 31-г тус тус хийсэн байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1990787.1 төгрөгийн мөнгөн дүн бүхий 366 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 22.5, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 10.1 байна.

Онцгой байдлын газраас короновирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Амны хаалт" нэгдсэн арга хэмжээг 2-р сарын 10-13-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд аймгийн төрийн болон хувийн хэвшлийн нийт 164 аж ахуй аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагч, түрээслэгч, томоохон зах худалдааны төвүүдээр үйлчүүлж буй иргэд нийт 8000 гаруй хүнд шинэ короновирусээс урьдчилан сэргийлэх, амны хаалт тогтмол зүүх, байгууллагуудыг амны хаалттай иргэдэд үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөмж тарааж ажилласан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах заавар"-ын дагуу хүний халдварт өвчний дэгдэлтийн үед ажиллах бүрэлдэхүүн, салбарын түвшинд мэдээлэл дамжуулах схемийг боловсруулж томилгоожуулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Цагаан сарын хяналтаар нийт 112 хүнсний худалдааны цэг, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 38 цэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 01/33 дугаар мэдэгдэх хуудсыг 19 сумын Засаг дарга, хүнсний худалдаа эрлэгч, нийт 150 газарт хүргүүллээ.

Хүнсний зах, худалдааны төвүүдийн эрүүл ахуйн нөхцөлийг хангуулахаар Хасу, Тэрх нийтийн худалдааны төвд 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр, "Архангайд үйлдвэрлэв" худалдааны төвд 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгэж Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Зооноз өвчин судлалын төв хамтран нийт 151 лангуу түрээслэгчид сургалт зохион байгууллаа. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 32 нэр төрлийн 152 ширхэг 37.4 кг 610300 төгрөгний хадгалах хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг устгалаа.

Архангай аймгийн хэмжээнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран хяналт шалгалт хийснээр ил задгай хүнсний худалдааг 100% таслан зогсоолоо.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр

"Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 1-р сарын 27-ны өдрийн А/43 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны 1-р сарын 27-ны өдрийн а/22 дугаар

захирамж, 01 дүгээр албан даалгаврын дагуу өмчийн бүх хэлбэрийн Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд харах төвүүдийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, удирдамж чиглэлийг шуурхай хүргүүлж ажиллаж байна.

2-р сарын 10-ны өдрөөс 4-р сарын 15-ны өдрүүдэд Элсэлтийн ерөнхий шалгалтын онлайн бүртгэлийн хугацаа эхэлсэнтэй холбогдуулан Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд зөвлөмж хүргүүлж хичээл, сургалтын үйл ажиллагааг 3-р сарын 30-ны өдрийг хүртэл хойшлуулсантай холбогдуулан Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлийг хэрхэн явуулах талаар Боловсролын үнэлгээний төвөөс удирдамж, чиглэл аван ажиллаж байна.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан гэрээр ном олгох үйлчилгээгээр нийтийн уншлагын танхимаар 15 уншигч шинээр бүртгэж, 50 ирэгсэдэд 156 ном, хэвлэлээр, хүүхдийн уншлагын танхимаар шинээр 9 уншигч бүртгэж, 38 ирэгсэдэд 108 номоор, хэвлэлээр, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 25 уншигч шинээр бүртгэж, 80 ирэгсэдэд, 220 номоор тус тус үйлчилсэн байна.

2020 оны 2-р сарын 03-наас 10-ныг хүртэлх хугацаанд аймгийн Хөгжимт драмын театр, СУИС-тай хамтран мэргэжлийн багш нарын удирдлаган дор “Орчин цагийн театрын хөгжлийн чиг хандлага” сэдэвт сертификаттай мэргэшүүлэх сургалтад 8 дуучин, 6 хөгжимчин, 7 бүжигчин, 5 жүжигчин, нийт 26 уран бүтээлчийг хамрууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр

Аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож, шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиудыг оролцуулан боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулсан.

Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын “Зөвлөх баг”, сэжигтэй тохиолдлын дуудлаганд үйлчлэх “Шуурхай баг”-ийг тус томилсон.

Эрүүл мэндийн газар дээр 24 цагаар шуурхай штаб ажиллаж, нийт 8 удаа хуралдаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр асуудлуудыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

Амны хаалт, эмийн хангамжийн чиглэлээр нийгмийн хариуцлагын гэрээг 20 эмийн сантай байгуулж, шаардлагатай тохиолдолд эмнэлэг дэлгэх чиглэлээр нийгмийн хариуцлагын гэрээг 6 хувийн хэвшлийн ортой эмнэлэгтэй байгуулсан.

Эрүүл мэндийн газраас аймгийн төв буюу Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлчилгээний газар, банк, худалдааны төв, зах зэрэг нийт 45 байгууллагын үүдний хэсэг, мэдээллийн самбарт шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг зурагт хуудсыг А2 хэмжээгээр хэвлүүлэн байршуулсан.

Архангай аймаг дахь Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүх шинжилгээний алба, Авто тээврийн төвийн нийт 94 албан хаагчдад “Шинэ коронавирусын халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хувцас өмсөх” сургалтыг зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн.

Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад аймгийн эрүүл мэндийн салбарт нэн тэргүүнд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийг авахад шаардлагатай 34.771.000 төгрөгний санхүүжилтийг яаралтай шийдвэрлүүлэх хүсэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлж, Засаг даргын нөөц хөрөнгөөс 19.4 сая төгрөгийг шийдүүлэн аймгийн Нэгдсэн эмнэлэгт зайнаас халуун хэмжигч 2, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 5, холтер аппарат -1, бүх сумын эрүүл мэндийн төвүүдийг тус бүр 1 зайнаас халуун хэмжигчээр хангалаа.

Өвчлөлийн тохиолдол бүртгэгдэхэд Нэгдсэн эмнэлгийн халдварт, сүрьеэгийн тасгийг бүрэн чөлөөлж, 30 ортой эмнэлэг дэлгэн ажиллуулах бэлэн байдлыг хангасан.

ЭМГ-ын төсвөөс нийт 1.7 сая төгрөгийг гарган зайнаас халуун хэмжигч 3, иж бүрэн хамгаалах хувцас 10, богино долгионы станц 3, автомакс 1, бээлий, маск, санитол зэргийг нөөцөнд бэлтгэсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

2020 оны 2-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1080 иргэн бүртгэлтэй байгаагаас 555 эмэгтэй, Шинэ ажлын байр 41, үүнээс байнгын ажлын байр 38, улирлын ажлын байр 3, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 38, зуучлал 31 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 32 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 10, бага-24, суурь-172, бүрэн дунд-658, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 24, тусгай мэргэжлийн дунд-19, Дипломын бакалаврын-173 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 10 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар нийт 1741.03 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 13.4 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 4.5 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 518.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2019 онд 1741.03 сая төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 264.46 сая төгрөгөөр өсчээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

2019 оны эцэст 17.3 мянган малчин, мал бүхий өрхөд 6167.0 мянган толгой мал үүнээс тэмээ 1.4 мянга, адуу 425.9 мянга, үхэр 710.1 мянга, хонь 3321.3 мянга, ямаа 1708.4 мянган толгой тоологдсон байна. Малын тоо толгойг өмнөх онтой харьцуулахад 11.2 хувь буюу 675.6 мянган толгойгоор өссөн үзүүлэлт гарсан

Аймгийн хэмжээнд 2020 онд нийт 2652.1 мянган эх мал төллөхөөс өнөөдрийн байдлаар 952 эх мал төллөж 883 толгой төлийг 93 хувьтай бойжуулж байна.

2-р сарын байдлаар нийт нутгийн 70 хувь нь цасан бүрхүүлтэй, ихэнх сумдын нутгаар цасны дундаж өндөр 0-5 см, Цэнхэр, Төвшрүүлэх, Хотонт, Булган, Жаргалант, Цэцэрлэг, Цахир сумдын зарим нутгаар 8-20 см цасан бүрхүүл тогтож, өнгөрсөн зун зуншлага тааруу байсан Хайрхан, Цэцэрлэг, Өлзийт, Өгийнуур,

Хашаат сумдын нийт нутгийн 45-70 хувь нь харын зудтай цаашид цас нэмж орвол өвөлжилт хаваржилт хүндрэх төлөвтэй байна.

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч болзошгүй байгаа учраас Монгол Улсын Шадар сайд Архангай аймагт ажиллах үеэрээ 120 тн өвс үнэгүй, 120 тн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгохоор шийдвэрлэсэн.

Завхан, Баянхонгор Өвөрхангай аймгийн зарим сумдаас манай аймгийн 14 сумын нутагт 142 өрхийн 134.8 мянган толгой мал отроор өвөлжиж байна.

Бэлчээрт цасан бүрхүүл тогтож малд идэгдэх идэш хомсдож мал сүрэг бэлчээрээс бүрэн хооллох боломж муудаж байна. Аймгийн хэмжээнд малчид 76.3 мянган тн өвс, 1287 тн гар тэжээл, 190 тн сүрэл, 1554 тн ногоон тэжээл, 877 тн үйлдвэрийн тэжээл, 1639 тн давс хужир шүү бэлтгэн авснаас одоогийн байдлаар 80 орчим хувийг нь зарцуулаад байна.

Аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 2350 тн байгалийн хадлан, 670 тн тэжээл бүрдүүлэхээс 1244.5 тн өвс, 486.5 тн тэжээл төвлөрүүлсэн нь 57.0 хувьтай бэлтгэж зарцуулж дууссан.

Аймгийн аюулгүй нөөцөөс Жаргалант, Цэцэрлэг, Цахир, Хангай сумдад 10 тн өвс, 18.7 тн ногоон тэжээлийг үнэгүй, 22.5 тн хивэг, 8.0 тн ашигт долооцыг хямдралтай үнээр олгосон.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгтэй хамтран “Уур амьсгалын өөрчлөлт малчдын амьдралд хэрхэн нөлөөлөх нь” судалгааг Булган сумын хэмжээнд 100 гаруй өрхийн 200 шахам малчдыг хамруулан зохион байгууллаа. Судалгааны материалыг нэгтгэх ажил хийгдэж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын аялал жуулчлалын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн “ITM-2020” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох бэлтгэлээ хангаж, 84м² талбайг захиалан, аялал жуулчлалын байгууллагуудад мэдээлэл хүргэж аймгийн аялал жуулчлалын газрын зургийг англи хэл дээр бэлтгэн 2000 ширхэгийг хэвлүүлээ.

Дэд бүтцийн чиглэлээр

2020 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга угсралт их засварын ажлын байршил тогтоох, зургийн даалгавар боловсруулах ажлаар 2020 оны 2-р сарын 1-нээс 10-ны өдрийн хооронд Ихтамир, Өндөр-Улаан, Хангай, Тариат, Чулуут, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Хашаат сумдад ажиллалаа.

ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны а/05 дугаар тушаалын дагуу газрын төлбөр, татварын системийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд өмнөх онуудын газрын төлбөрийг мэдээллийн санд /вэб хувилбар/ нөхөн оруулж ГЗБГЗЗГ-т хүргүүлэн Татварын ерөнхий газар, ГЗБГЗЗГ-ын дундын мэдээллийн санд илгээж 2020 оны газрын төлбөрийн ноогдуулалтыг үүсгэсэн.